



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/78

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн алба хаагчдын согтуурлын зэрэг шалгагч тандагч багаж 4 ширхэгийг худалдан авахад зориулж 2.640.000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 2.640.000 төгрөг /хоёр сая зургаан зуун дөчин мянга/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний 5.21 дэх заалт "Тайван амгалан Ховдчууд" хөтөлбөр, төслөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ